

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА,
ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ**

2012 оны 8 дугаар сарын 22 ны өдөр

Дугаар 167/05

Улаанбаатар хот

Хилийн боомтод даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулах компанийг сонгон шалгаруулах журам батлах тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Хилийн тухай хуулийн 34.2.6, Хууль зүй дотоод хэргийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2012 оны А/23/24 тоот тушаалаар батлагдсан "Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон түр хугацаагаар орж ирж байгаа автотээврийн хэрэгсэл эзэмшигч, өмчлөгчийг жолоочийн даатгалд хамруулах журам"-ын 2.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1.Хилийн боомтод даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулах даатгалын зуучлагч байгууллагыг сонгон шалгаруулах журмыг нэгдүгээр хавсралтаар, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал явуулах хилийн боомтуудын багцыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. "Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон түр хугацаагаар орж ирж байгаа автотээврийн хэрэгсэл эзэмшигч, өмчлөгчийг жолоочийн даатгалд хамруулах журам"-ын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хил хамгаалах ерөнхий газрын тэргүүн дэд дарга бөгөөд хилийн цэргийн штабын дарга, бригадын генерал А.Лхагвасүрэн, Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга С.Ганболд нарт даалгасугай.

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ХИЛ ХАМГААЛАХ ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ

Т.СЭРГЭЛЭН

46

Санхүүгийн зохицуулах хорооны дарга,
Хил хамгаалах ерөнхий газрын даргын
2012 оны 8 дугаар сарын 28 ны өдрийн
117 дүгээр тушаалыг нэгдүгээр хавсралт

УХА0410 5043239

**ХИЛИЙН БҮСЭД ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЯВУУЛАХ ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ КОМПАНИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Хилийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Хууль зүй дотоод хэргийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2012 оны А/23/24 тоот тушаалаар батлагдсан “Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон түр хугацаагаар орж ирж байгаа автотээврийн хэрэгсэл эзэмшигч, өмчлөгчийг жолоочийн даатгалд хамруулах журам”-ыг үндэслэн хилийн бүсэд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын зуучлал хийх байгууллагыг сонгон шалгаруулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Даатгалын зуучлагч компани нь хилийн бүсэд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг хилийн боомтуудын багцаар хийж гүйцэтгэнэ.

1.3. Даатгалын зуучлагч компани нь багц дахь хилийн боомтуудын чиглэлд жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагааг төлөөлөн ажиллаж буй давтагчидтай харилцан зөвшилцөн хамтын ажиллагааны гэрээ хийж, хилийн бүсэд даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулах сонгон шалгаруултанд оролцоно.

1.4. Хил хамгаалах байгууллага нь Монгол Улсын Хилийн тухай хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн даатгалын зуучлагч компани жолоочийн хариуцлагын албан журмын даатгал хийх цэгийг улсын хилийн бүсэд тогтоон өгч холбогдох зөвшөөрлийг өгнө.

Хоёр. Сонгон шалгаруулалт явуулах журам

2.1. Монгол Улсын хилийн бүсэд даатгалын зуучлалын үйл ажиллагаа хийх байгууллага нь сонгон шалгаруултанд тавигдах шаардлага, холбогдох баримт материалыг хүлээн авах болон сонгон шалгаруулалт явуулах газар, хугацааг олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр эсвэл албан бичгээр урьдчилан мэдээлнэ. Хугацаа хоцорсон материалыг хүлээн авахгүй.

2.2. Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр болон албан бичгээр мэдээллэх жуудлыг Санхүүгийн зохицуулах хороо хариуцна.

2.3. Хил хамгаалах ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан ажлын хэсгийн /цаашид "Ажлын хэсэг" гэх/ хуралдаанаар хилийн бүсэд даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулах сонгон шалгаруулалтад оролцохоор хүсэлт гаргаж материалаа ирүүлсэн даатгалын зуучлагч компанийн албан ёсны төлөөллийг байлцуулан сонгон шалгаруулалтын материалыг хэлэлцэнэ.

2.4. Тавигдах шаардлагыг хангаагүй материалыг сонгон шалгаруулалтад оруулахгүй мэднэ. Энэ талаар тухайн даатгалын зуучлагч компанийн төлөөлөлд танилцуулж, протоколд тусгана.

2.5. Хилийн бүсэд даатгалын зуучлал хийх даатгалын зуучлагч компанийн материалыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга ажлын хэсгийн хуралдаанд танилцуулна.

2.6. Хилийн бүсэд даатгалын зуучлал хийх компанийн ажлын хэсгийн хуралдаанаар сонгон шалгаруулж, дүнг шалгаруулалтад оролцсон нийт даатгалын зуучлалын компанид танилцуулна.

2.7. Сонгон шалгаруултад тэнцсэн даатгалын зуучлагч компанитай Хил хамгаалах ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо улсын хилийн бүсэд жолоочийн хариуцлагын албан журмын даатгал хийх гурвалсан гэрээг нэг жилийн хугацаатай байгуулна.

2.8. Хил хамгаалах ерөнхий газар гэрээ байгуулсан даатгалын зуучлагч компанид жилийн бүсэд ажиллах зөвшөөрлийг гэрээнд заасан хугацааг үндэслэн олгоно.

2.9. Хилийн бүсэд ажиллах хугацаа дууссан даатгалын зуучлагч компанийг дараагийн жил үргэлжлүүлэн ажиллуулах, эсхүл шинэ аж ахуйн нэгжийг сонгон ажиллуулах талаар Санхүүгийн зохицуулах хороо Хил хамгаалах ерөнхий газар хамтарч шийдвэрлэнэ. Шинээр даатгалын зуучлагч компани сонгон шалгаруулах тохиолдолд энэхүү журмыг мөрдөнө.

Гурав. Сонгон шалгаруулалтад тавигдах шаардлага, түүнийг баталгаажуулах материал

3.1. Хилийн боомтод даатгалын зуучлал хийх даатгалын зуучлагч компани нь дараахь шаардлагыг хангасан байна.

3.1.1. Даатгалын зуучлал хийх тусгай зөвшөөрөлтэй, даатгалын салбарт нэг буюу түүнээс дээш жил ажилласан ажлын дадлага туршлагатай мэргэжилтэнтэй, хууль зүйн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг байх;

3.1.2. Санхүүгийн чадавхитай байх;

3.1.3. Хоёр буюу түүнээс дээш даатгалын компанид жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын зуучлал хийхээр байх;

3.1.4. Хил хамгаалах байгууллагаас хилийн бүс дэх боомт бүрийн чиглэлд тусгайлан тогтоож өгөх цэгт үйл ажиллагаагаа явуулах боломжтой байх;

3.1.5. Хилийн бүсэд ажиллах ажлын туршлага бүхий боловсон хүчний нөөцтэй байх;

3.1.6. Хилийн бүсэд үйл ажиллагааг тасралтгүй найдвартай явуулах, мөн хяналт тавих боломжоор хангагдсан байх;

3.1.7. Тухайн даатгалын зуучлагч компани нь Монгол Улсын хууль тогтоомж зөрчсөн аливаа үйлдэл гаргаагүй байх;

3.2. Даатгалын зуучлагч компани нь үйл ажиллагаагаа явуулах хилийн боомтын чиглэлд өөрийн салбартай байх нь сонгон шалгаруулалтад давуу тал болно.

3.3. Энэ журмын 3.1-д заасан шаардлагыг дараахь байдлаар баталгаажуулна.

3.3.1. Даатгалын зуучлал хийх тусгай зөвшөөрөлтэй, даатгалын салбарт нэг буюу түүнээс дээш жил ажилласан ажлын дадлага туршлагатай мэргэжилтэнтэй, хууль зүйн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг байх шаардлагын хүрээнд:

-Тухайн даатгалын зуучлагч компани Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн орлоогчийн тухай хууль зэрэг холбогдох хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах тухай Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар, ажиллах мэргэжилтнүүдийн анкет СЗХорооны 2008 оны 61 шатлоолоор баталсан журмын 3-р хавсралтаар баталсан маягтаар, даатгалын зуучлагч компанийн санхүүгийн тайлан, тайлангийн дүгнэлт.

3.3.2. Санхүүгийн чадавхитай байх шаардлагын хүрээнд:

-Тухайн даатгалын зуучлагч компанийн санхүүгийн чадавхийн талаарх харилцагч банкнуудад зээлтэй эсэх, мөн өөрийн өр төлбөрийн талаарх тодорхойлолтууд

3.3.3. Хоёр буюу түүнээс дээш даатгалын компанид жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын зуучлал хийхээр байх шаардлагын хүрээнд:

-Даатгагч, даатгуулагчийн эрх ашгийг хангах зорилгоор 2 буюу түүнээс дээш даатгалын компанийг төлөөлөх эрхтэйг баталгаажуулсан жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын зуучлал хийх гэрээ;

-Ижил тэгш нөхцөлөөр даатгалын зуучлал хийх талаар даатгалын компаниудтай байгуулсан гэрээ;

3.3.4. Хил хамгаалах байгууллагаас хилийн бүс дэх боомт бүрийн чиглэлд тусгайлан шатгоож өгөх цэгт үйл ажиллагаагаа явуулах боломжтой байх шаардлагын хүрээнд:

- Тухайн хилийн бүсэд даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулах ажлын байртай байх. /түрээсийн гэрээ болон бусад хэлбэрийн сонголттой эсэх/

-Ажлын байрны цаашдын шийдвэрийн талаарх танилцуулга;

3.3.5. Хилийн бүсэд ажиллах ажлын туршлага бүхий боловсон хүчний нөөцтэй байх шаардлагын хүрээнд:

-Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалд хамруулах журамд заасны дагуу тухайн хилийн бүсийн боомтын чиглэлд тогтвортой ажиллах ажилтны анкет, мөн тасралтгүй ажиллах нөхцөлийг хангах арга хэмжээний талаарх танилцуулга.

-Тухайн ажилтны гэмт хэрэг зөрчилд холбогдож байгаагүй талаарх цагдаагийн байгууллагын тодорхойлолт;

3.3.6. Хилийн бүсэд үйл ажиллагааг тасралтгүй явуулах, түүнийг хянах чадвартай байх шаардлагын хүрээнд:

-Даатгалын зуучлагч компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, түүний үйл ажиллагааны сүүлийн жил, улирлын санхүүгийн тайлан;

-Хилийн бүс дэх өөрийн үйл ажиллагаагаа хянах дотоод хяналтын системийн талаарх мэдээлэлгүй танилцуулга;

3.3.7. Тухайн даатгалын зуучлагч компани нь Монгол Улсын хууль тогтоомж зөрчсөн аливаа үйлдэл гаргаагүй байх шаардлагын хүрээнд:

-Даатгалын зуучлалын үйл ажиллагаа, татвар, гэмт хэргийн аливаа зөрчилд холбогдоогүйг холбогдох эрх бүхий байгууллагуудаас нотолсон албан бичиг;

3.4. Дээрх шаардлага, нотолгоог хангасан баримт бичиг эх хувиараа, хуулбар бол хуульчид баталгаажуулсан байна.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Хилийн бүсэд тусгайлан тогтоож өгөх цэгээс өөр газарт даатгалын зуучлалын үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

4.2. Санхүүгийн зохицуулах хороо, Хил хамгаалах ерөнхий газар, даатгалын зуучлагч байгууллагын хамтарсан гэрээг цуцлах тохиолдол:

-Даатгалын зуучлагч компни нь гэрээнд заасан нөхцөл, хүлээсэн үүргээ биелүүлээгүй;

-Жолоочийн даатгалын тухай, даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай зэрэг хууль тогтоомжуудыг зөрчсөн;

-Хилийн тухай хууль, хилийн болон хил орчмын дэглэм, энэхүү журмын 4.1. дэх шаардлыг зөрчсөн;

1	Хил	Хил орчмын дэглэм	
2	Хил	Хил орчмын дэглэм	
3	Хил	Хил орчмын дэглэм	
4	Хил	Хил орчмын дэглэм	
5	Хил	Хил орчмын дэглэм	
6	Хил	Хил орчмын дэглэм	
7	Хил	Хил орчмын дэглэм	
8	Хил	Хил орчмын дэглэм	
9	Хил	Хил орчмын дэглэм	
10	Хил	Хил орчмын дэглэм	
11	Хил	Хил орчмын дэглэм	
12	Хил	Хил орчмын дэглэм	
13	Хил	Хил орчмын дэглэм	
14	Хил	Хил орчмын дэглэм	
15	Хил	Хил орчмын дэглэм	
16	Хил	Хил орчмын дэглэм	
17	Хил	Хил орчмын дэглэм	
18	Хил	Хил орчмын дэглэм	
19	Хил	Хил орчмын дэглэм	
20	Хил	Хил орчмын дэглэм	

Санхүүгийн зохицуулах хорооны дарга,
Хил хамгаалах ерөнхий газрын даргын
2012 оны 9 дугаар сарын 22 ны өдрийн
167/25 дүгээр тушаалыг хоёрдугаар хавсралт

ЖОЛООЧИЙН ХАРИУЦЛАГЫН АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ХИЛИЙН АВТОЗАМЫН
БООМТУУДЫН БАГЦ

№	Багцын дугаар	Д/д	Боомтын нэр	Боомтын зэрэглэл	Тайлбар
1	I багц	1	Замын Үүд	Олон улсын байнгын	
		2	Ульхан	Хоёр талын байнгын	
		3	Бургастай	Хоёр талын түр	Олон улсын зэрэглэлтэй болно.
		4	Тэс	Хоёр талын байнгын	
2	II багц	5	Шивээхүрэн	Хоёр талын байнгын	Олон улсын зэрэглэлтэй болно.
		6	Арцсуурь	Хоёр талын байнгын	
		7	Байтаг	Хоёр талын түр	
		8	Эрээнцав	Олон улсын байнгын	
3	III багц	9	Гашуунсухайт	Хоёр талын байнгын	Олон улсын зэрэглэлтэй болно.
		10	Цагааннуур	Олон улсын байнгын	
		11	Хавирга	Хоёр талын түр	Байнгын болно.
4	IV багц	12	Ханх	Хоёр талын байнгын	
		13	Булган	Олон улсын байнгын	
		14	Боршоо	Хоёр талын байнгын	
		15	Ханги	Хоёр талын түр	Байнгын болно.
5	V багц	16	Даян	Хоёр талын түр	Олон улсын зэрэглэлтэй болно
		17	Алтанбулаг	Олон улсын байнгын	
		18	Бичигт	Олон улсын байнгын	
		19	Баянхошуу	Хоёр талын түр	